



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 00/446
танай _____-ны № _____-т

ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧ А.АМАНКЕЛДИ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга, санал дүгнэлт бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

дэмжих нотлох зүйлсийг хангалттай
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 **ЗӨРЧИЛГҮЙ**
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M

Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 261885

Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: Ц.Цэрэнхүү

Утас: 261628

Цахим хаяг: TserenkhUU@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар-46
Цахим хуудас:**

**“Мишээл-Од Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Т.Одончимэг
Утас: 99069029, 96659029**

Ахлах аудитор: О.Цэндхүү
Аудитор, ЧХМ Э.Энхцэцэг
Аудиторын туслах: Б.Энхболор
Утас: 99065204

Хаяг: БГД 2 хороо Time center 601, 603

Вэб хуудас: www.misheelodaudit.mn

Имэйл хаяг: misheelod@yahoo.com

2018 оны 02 дүгээр сарын 23

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт3: Менежментийн захидал

Хавсралт4: Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хавсралт4: Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хавсралт4: Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хавсралт4: Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Хавсралт4: Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт4: Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Судалгаа: Орлого № 01

Зардал № Ц/01

Зардал № Ц/02

Зардал № НТ/03


Зардал № ГТ/04

Зардал № ТГ/05

Авлага № А/06

Үндсэн хөрөнгө № А/07

Өглөг № Ө/08



АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны талаарх мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын их хурал
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЧД	Чингэлтэй дүүрэг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дүгээр зүйлд заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /САГ-2018/48/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Цагааннуур чөлөөт бүс нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.


Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 23-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Мишээл-Од Аудит” ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар удирдан зохион байгуулж ахлах аудитор О.Цэндхүү, аудиторын туслах Б.Энхболор нар гүйцэтгэв.

Тус байгууллага нь 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 01 дүгээр сарын 24-нд 03 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 02 дугаар сарын 23-нд Цагааннуур чөлөөт бүсийн удирдлагад хүргүүлж байна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин



Цагааннуур чөлөөт бүс нь Чөлөөт бүсийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын ерөнхий хууль, зэрэг хуулиуд болон холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Цагааннуур чөлөөт бүсэд худалдаа, тээвэр ложистик, банк санхүүгийн үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, мэдээлэл, холбооны салбарыг хөгжүүлж, олон улсын чөлөөт бүсийн жишигт хүргэн, Монголын баруун бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд томоохон хувь нэмэр оруулах зорилготой байгуулагдсан байна.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн захирагч төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Цагааннуур чөлөөт бүсийн төсвийн санхүүжилтийг Сангийн яамны төрийн сангаас олгож, улсын төсвийн орлогоос бүрдэж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Цагааннуур чөлөөт бүсийн санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсгийг А.Аманкелди, хоёрдугаар гарын үсгийг М.Аманкелди нар зурж төсвийн хөрөнгийг зарцуулж байна.

Цагааннуур чөлөөт бүсийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-

СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 6 чиглэлээр 21 уламжлалт сорил, 7 хяналтын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай танилцахад Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн “ВИННИЦА” програмтай байна. Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “Бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тав. Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.


Цагааннуур чөлөөт бүсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “Бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон.

Төлөвлөлтийн шатанд 2017 оны төсөв өмнөх оноос 137,095.4 мянган төгрөгөөр буурсан тул 2017 оны батлагдсан төсвийг материаллаг байдлын суурь болгон авч 249,315.1 мянган төгрөгийн 2.0 %-иар буюу 4,986.3 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурийг 2017 оны төсвийн гүйцэтгэл 256,105.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 5,122.1 мянган төгрөгөөр тогтоож, аудитын горимуудыг гүйцэтгэхэд материаллаг хэмжээний зөрчил гараагүй болно.



Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг

боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Цагааннуур чөлөөт бүсийн төсвийн шууд захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 249,604.5 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөж, 256,105.0 мянган төгрөгийн орлого олж 255,512.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 1,240.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, тайлант хугацааны эцэст жижиг мөнгөн сангийн харилцах дансанд 24.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хууль батлагдан мөрдөх болсонтой холбогдуулан, 2015 оноос тус хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд шилэн дансанд холбогдох мэдээллүүдийг тус байгууллагын нягтлан бодогч байршуулж байна.

<http://shilendans.gov.mn> /kod-036000302/ цахим хуудасны Төсвийн ил тод байдлын тухай гэсэн цэсэнд байгууллагын батлагдсан 2017 оны төсөв, төсвийн гүйцэтгэлийн 1-12 сарын мэдээ, харилцах, кассаас зарцуулсан зарцуулалтуудыг бүрэн байршуулсан байна.

Үндэсний Аудитын газраас 2017 онд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар зөрчил дутагдал гараагүй, зөвлөмж өгөөгүй байна.


Ёс. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлд уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр уламжлалт 21, нарийвчилсан 7, нийт 28 горим, сорил гүйцэтгэв. Гүйцэтгэсэн сорилын үр дүнгээс харахад тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчил, дутагдал илрээгүй.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан горим сорилд тус байгууллагын нийт ажил гүйлгээний 90.0 хувь хамарсан байна.



Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад залруулагдах дараах алдаа илэрснийг залруулсан болно. Үүнд:

1. Хаан банкны харилцах дансны эхний үлдэгдэл 472.9 мянган төгрөгийг Төрийн сангийн харилцах дансны эхний үлдэгдэлд тусгаснаас тайлант оны эцсийн үлдэгдэл 472.9 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Аудитын *Толилуулга ба тодруулга*: “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасан байх гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулга хийлгэсэн

2. Шилэн дансны веб сайтад мэдээлэл байршуулахдаа 2017 оны төсвийн гүйцэтгэл 249,604.5 мянган төгрөгийг 24,910,501.2 мянган төгрөг гэж 24,660,896.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д заасны дагуу “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.


Мөн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг шилэн дансанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.5-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор байршуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны веб сайтад зөрүүтэй байршуулсан 24,660,896.7 мянган төгрөгийн зөрүүг залруулж, 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, тайлан, зөвлөмж, албан шаардлагыг байршуулсан.

3. Тайлант оны эцсийн санхүүгийн тайланд ажилтнаас авах авлага дансанд 2 ажилтантай холбоотой 42.4 мянган төгрөг, байгууллагаас авах авлага дансанд 1 байгууллагатай холбоотой 126.8 мянган төгрөгийн авлага “хасах” үлдэгдэлтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.2.1-д заасны дагуу “Ажил үйлчилгээ үзүүлсэн, бараа, бэлэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан, эсвэл бусдад шилжүүлсэн аливаа зүйлстэй холбоотой нэхэмжилсэн, төлөгдөх хугацаа нь дуусмагц мөнгө болж хувирах зүйлсийг авлага гэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 169.2 мянган төгрөгийн авлагыг залруулсан.

4. Шүүгчийн 5638 дугаар захирамжаар илүү олгосон 2,129.5 мянган төгрөгийн цалин, компьютерын үнэ 1,250.0 мянган төгрөг нийт 3,379.5 мянган төгрөгийг тус байгууллага буцаан авахаар шийдвэр гарсан байна. Гэтэл санхүүгийн тайланд 3,929.5 мянган төгрөгийн авлагыг урьдчилж төлсөн зардал дансанд тусгаж 550.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна. Энэ нь тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.2.1-д “Урьдчилж төлсөн зардал нь тайлант хугацаанд мөнгөөр гарсан боловч дараагийн тайлант хугацаанд зардал



буюу бараа, үйлчилгээгээр тооцогдох ирээдүй цагийн зарлагыг илэрхийлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэгдсэн 3,929.5 мянган төгрөгийг авлагын дансанд тусгуулж залруулсан.

5. Өмнөх оны аудитын залруулгаар урсгал засварын зардалд зарцуулсан 472.9 мянган төгрөг, “Голден пэйж Аудит” ХХК-д төлөх аудитын төлбөрийн үлдэгдэл 1,100.0 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт өгөх түрээсийн төлбөрийн 20.0 хувь 56.0 мянган төгрөгийн өр төлбөрийг дансанд тусгахдаа харилцагч тус бүрээр бүртгэлгүй бөөн дүнгээр нь буюу 1,628.9 мянган төгрөгийг Цагааннуур чөлөөт бүсэд өгөх өр гэж бүртгэсэн байна. Энэ өр төлбөрөөс 472.9 мянган төгрөгийн өрийг тайлант онд барагдуулсан байна. Үүнийг нягтлан бодогч бүртгэлд тусгахдаа дансны өр болон урсгал засварын зардлыг нэмэгдүүлэн давхар бүртгэсэн байна. Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг харилцагч тус бүрээр журналд тусгуулж, давхар бүртгэсэн 472.9 мянган төгрөгийн зардлыг бууруулж залруулсан.

6. Бараа материал дансны үлдэгдэл тооллогын бүртгэлээс 1,159.5 мянган төгрөгөөр илүү бүртгэгдсэн. Тус зөрүү нь Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн 2016 оны Б/02 дугаар захирамжаар 32 нэр төрлийн 2,279.2 мянган төгрөгийн бараа материал данснаас хасах шийдвэр гаргаж устгасан боловч 27 нэр төрлийн 1,159.5 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хасаагүйтэй холбоотой байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Устгалд орсон 1,159.5 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хасч тайланд залруулга хийсэн.

7. Бараа материалын журналын үлдэгдэл нь санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдлээс 671.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна. Энэ нь Аудитын “Иж бүрэн байх” батламж мэдэгдэлд: “аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Зөрүүтэй илэрхийлэгдсэн 671.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл нь өмнөх оны бараа материалын үлдэгдлийг дутуу бүртгэсэнтэй холбоотой байсныг залруулсан.

Аудитын явцад залруулагдаагүй, материаллаг бус дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. Авлага дансанд зөрүүтэй бүртгэсэн 550.0 мянган төгрөгийн авлага, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй хэнээс авах нь тодорхойгүй 157.4 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

2. Анхны өртгөө элэгдлээрээ нөхөж тэг үлдэгдэлтэй болсон 217,301.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС-17-ийн 49-д “Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС-17-ийн 49 дахь заалтын дагуу дахин үнэлгээ хийх, цаашид ашиглахгүй хөрөнгийг данснаас хасах талаар холбогдох дээд шатны байгууллагад хандах талаар зөвлөмж өгөх

3. Цагааннуур чөлөөт бүс нь 2017 оны төсвийг 5,908.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Бид аудитын явцад залруулагдах боломжтой 7 алдааг залруулж, 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.



Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг баталгаажуулахаар аудитын явцад

санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгасан учир дараагийн аудитаар авч үзэх ноцтой асуудлууд байхгүй гэж бид үзсэн болно.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын явцад материаллаг бус нийт 228,492.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,575.0 мянган төгрөгийн 7 зөрчил залруулагдаж, 223,917.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлэв. Үүнээс анхны өртгөө элэгдлээрээ нөхөж тэг үлдэгдэлтэй болсон 217,301.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийг материаллаг бус зөрчил гэж үзлээ.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цагааннуур чөлөөт бүсийн 2016 оны санхүүгийн тайланд “Голден пейж Аудит” ХХК аудит хийж 4 албан шаардлага, 5 зөвлөмж өгсний 4 албан шаардлага, 3 зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

Албан шаардлага, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Цагааннуур чөлөөт бүсийн даргын 2018 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 05 тоот албан тоотой ирүүлснийг тайланд хавсаргасан болно.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийсэн санхүүгийн тайлан 10 хуудас, Цагааннуур чөлөөт бүсийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 17 хуудас, хавсралтууд 12 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ



ХЯНАСАН:

“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ, АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ

Т.ОДОНЧИМЭГ

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

О.ЦЭНДХҮҮ

2018 оны 2 дугаар сарын 23



ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
хаягаар харилцана уу:**

**САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг**
Утас: 261663
Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: Ц.Цэрэнхүү
Утас: 261628
Цахим хаяг: tserenkhuuts@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46**

**“Мишээл-Од Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Т.Одончимэг**
Утас: 99069029, 96659029

Ахлах аудитор: О.Цэндхүү
Аудитор Э.Энхцэцэг
Аудиторын туслах: Б.Энхболор
Утас: 99083461, 99065204
Хаяг: БГД 2 хороо Time center 601, 603
Вэб хуудас: www.misheelodaudit.mn

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1

Төсвийн гүйцэтгэлийн талаар.....3

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 2

Авлагын бүртгэлийн талаар.....4

Асуудал 3

Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар.....5



2018 оны 02 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Цагааннуур чөлөөт бүсийн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай компанийн үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цагааннуур чөлөөт бүсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ҮАГ-ын ажиглалт

1. Цагааннуур чөлөөт бүс нь 2017 оны төсвийг 5,908.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчиж байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой боловсруулж, үйл ажиллагаагаа батлагдсан төсвийн хүрээнд удирдан зохион байгуулж

Эрсдэлүүд

1. Төсвийн тухай хуулийг зөрчсөн байх
2. Зардлыг хэтрүүлэн зарцуулсан байх
3. Холбогдох хууль, журам, стандартын заалтыг зөрчсөн байх

Үйлчлүүлэгчийн хариу

Төсвийн тухай хуулийг мөрдөж, 2018 оноос төсвийг хэтрүүлэхгүй ажиллана.



ҮАГ-ын ажиглалт

4. Авлага дансанд зөрүүтэй бүртгэсэн 550.0 мянган төгрөгийн, хэнээс авах нь тодорхойгүй 157.4 мянган төгрөгийн авлагууд бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

1. П.Энхжаргалаас авах 550.0 мянган төгрөгийн авлагын үндэслэл мөн эзэн холбогдогч нь тодорхойгүй 157.4 мянган төгрөгийн авлагын хариуцах эзнийг тогтоож, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах.

Эрсдэлүүд

1. Санхүүгийн тайланд авлага тусгагдаагүй байх буюу зөрүүтэй илэрхийлэгдсэн байх.
2. Санхүүгийн тайланд үндэслэлгүй авлага бүртгэгдсэн байх.
3. Авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Өмнөх оны тооцоог дахин хянаж, авлагын эзэн холбогдогчийг

тодруулан авлагыг барагдуулах ажил зохион байгуулна

01 **ЗӨРЧИЛГҮЙ**
САНАЛ ДҮГНЭЛТ

ҮАГ-ын ажиглалт

1. Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 217,301.2 мянган төгрөгийн хөрөнгө ашиглагдаж байна. Энэ нь УСНББОУС-17-гийн 49-д “Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна

Эрсдэлүүд

1. Үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй байх /ИБ, ОБ, ЭҮ, ТИ/
2. Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байх /ИБ, ОБ, ЭҮ, ТИ/
3. Холбогдох хууль, тогтоол, журам, стандарт зөрчсөн байх /ОБ, ЭҮ, ТИ/

ҮАГ-ын зөвлөмж

1. Анхны өртгөнөхсөн 217,301.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг УСНББОУС-17-гийн 49-д заасны дагуу дахин үнэлж ашиглалтын хугацааны элэгдлийг тооцох талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар шийдвэрлүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох байгууллагад санал хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ

Т.ОДОНЧИМЭГ

БЭЛТГЭСЭН:

“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР

Э.ЭНХЦЭЦЭГ

Огноо: 2018.02.21



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Аудитаар баталгаажсан үлдэгдэл			
